



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД:ХОА-2023/30-20-ШТА-НА

Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуулийн дагуу төлөвлөөгүй, зардлыг журамд заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545

Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Цахим хаяг: oyunjargals@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээлэлийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёо.....	4
Графикийн товъёо.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
Ерөнхий зүйл.....	6
БҮЛЭГ А. Хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн ч төсвийн захирагч нартай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээг тусгаагүй, хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй байна.	7
A1.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай зарим хууль, тогтоомжийн заалтууд зөрчилдөж байна.....	7
A1.2 Аймгийн богино болон дунд хугацааны баримт бичгийг баталж, байгаль орчинтой холбоотой дэд хөтөлбөрүүд 81.8 хувьтай биелсэн байна.....	7
A1.3 Байгалийн нөөц ашиглагч байгууллагууд менежментийн төлөвлөгөөг батлуулан дүгнүүлж байгаа ч төрийн зарим байгууллагууд менежментийн төлөвлөгөөгүй байна.	8
A2.1 БОАЖ-ийн сайд нь Аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан ч биелэлтийг тооцох шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг зөв тодорхойлоогүйгээс үнэлгээ бодитой хийгдэхгүй байна.....	9
A2.2 Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаагүй байна.....	10
БҮЛЭГ Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арага хэмжээний зардлыг хуулийн дагуу төлөвлөгөөгүй, бүрдүүлсэн орлогыг хуульд заасны дагуу зарцуулаагүй байна.....	11
B1.1 Ан амьтан, ойн нөөцийг тогтоосон ч бусад байгалийн нөөцийг тогтоогүй байхад ашиглах төрөл дээд хэмжээг тогтоосон байна.	11
B.1.2 Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	11
B.1.3 Зарим иргэн, хуулийн этгээд байгалийн нөөцийг зөвшөөрөлгүй ашиглаж байна.....	12
B.1.4 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж бүрэн ногдуулаагүйгээс төсөвт орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсаар байна.....	14
B.2.1. Байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцон батлаагүй байна.....	16
B.2.2. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан арга хэмжээнд зарцуулахгүй, хүрэлцэхгүй байгаа бусад арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж байна.....	18
БҮЛЭГ В. Хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн ч хяналт, шалгалтын үр дүн тодорхойгүй байна.....	20
B.1.1 Байгаль орчны цахим сангийн мэдээлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн ч мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.	20
B.1.2 Төрийн байгууллагуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын талаарх мэдээлэл зөрүүтэй байна.....	20
B.2.1. Байгаль орчны чиглэлийн байгууллагууд хуульд заасны дагуу хяналт хэрэгжүүлж харин ГХБХБГ-ын хяналт сул байна.....	21
B2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн ч зөрчил буураагүй байна.....	22
Холбогдох байгууллагын санал:.....	
Саналд өгсөн тайлбар:.....	

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
БХС	Байгаль хамгаалах сан
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
БОХ	Байгаль орчны хяналт
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОХНСАХЗ	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай байгууллага
ХУНОУТХГНХЗ	Хар усан нуур орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн
ХНХГСГЗ	хамгаалалтын захиргаа
	Хар нуур ховд голын сав газрын захиргаа
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮББГСГЗ	Үенч бодонч булган голын сав газрын захиргаа
УИХ	Улсын их хурал

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	8
Хүснэгт 2	Менежментийн төлөвлөгөөний судалгаа	9
Хүснэгт 3	Байгаль орчин аялал жуулчлалын сайд төсвийн захирагч нартай байгуулсан гэрээний хэрэгжилт	9-10
Хүснэгт 4	Байгаль орчин аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг харьцуулсан судалгаа	10
Хүснэгт 5	Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагч нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө	10
Хүснэгт 6	Байгалийн нөөцийг ашиглах төрөл дээд хэмжээ	11
Хүснэгт 7	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	14
Хүснэгт 8	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардал	16
Хүснэгт 9	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл	18
Хүснэгт 10	Системийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн судалгаа	19
Хүснэгт 11	БНАТ-ын орлогын ногдуулалт, төлөлт	20
Хүснэгт 12	Газрын төлбөрийн орлого, төлөлт	20
Хүснэгт 13	Мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт	20

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Ан амьтны нөөц /оноор/	11
График 2	Зөвшөөрөл олгосон, агнасан, агнаагүй ан амьтны тоо	12
График 3	Усны зөвшөөрөлт олголт	13
График 4	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого	14
График 5	Нийт орлогод байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын нэр төрлөөр эзлэх хувь	15
График 6	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө /2021-2023 он/	17
График 7	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл /2021-2022 он/	17

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилгыг чиглүүлж, аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: - Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх. - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх. - Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтийг хангах үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх талаарх эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд зөвшөөрөл гаргах эрх бүхий субъект, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, мэргэжлийн байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албадын 2021-2022 он, 2023 оны 1-4 сарын үйл ажиллагааг хамруулж горим сорилыг хэрэгжүүлсэн болно.
Аудитын хязгаарлалт	Аудитын явцад аймгийн Татварын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагуудын тоо мэдээлэл зөрүүтэй, ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн солигдсон, төрийн байгууллагуудын ажил хариуцаж байгаа зарим мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага сул, холбогдох мэдээ мэдээллийг цагт нь ирүүлдэггүй, хариуцсан ажлын талаарх дэлгэрэнгүй тоо мэдээ, судалгаа бүрэн бус, архивын нэгж үүсээгүй зэрэг асуудлууд аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001-д нийцүүлсэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”-ын стандарт арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудит байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дугаар “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга судалгаа авах, харьцуулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Ц.Аззаяа, А.Нарандэлгэр, С.Оюунжаргал нар гүйцэтгэлээ. Аудитыг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхэлж 2023 оны 06 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, шалгагдагч байгууллагуудаас санал авч, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан, Аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан.

Байгаль орчны салбарт 2020 оны байдлаар Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан 22 олон улсын гэрээ, конвенц, богино, дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх 20 бодлого, хөтөлбөр, салбарын болон салбар дундын 38 хууль, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй 95 журам, аргачлал, тус салбарт шууд хамаарах 434 үндэсний стандарт мөрдөгдөж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдсан бөгөөд төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөгдөх хөнгөлөх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хүрээнд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хүчингүй болгож 2022 оны 2 дугаар тогтоолоор шинэчлэн баталж хэрэгжүүлж байна.

Ховд аймгийн хэмжээнд Гадаргын усны нөөцийн нийт хэмжээ /сая м3/ 1049.37 Газар доорх усны нөөцийн хэмжээ /сая м3/ 2.24 нийт хамгаалалтын бүсэд 287645 га, татам буюу усан гадаргын талбай 862169 га, аймгийн хэмжээнд 1149814 сая га газрыг хамгаалалтад авсан байна. Хар-Нуур Ховд голын сав газрын нийт талбай 86120,9 ам км бөгөөд үүнээс Ховд голын сав газар 50419,2 ам км, Буянт голын сав газар 8393.5 ам км, нууруудын сав газар 27578.2 ам км талбай эзэлж байна.

Аймгийн ойн сан бүхэлдээ буюу 812921 га талбай хамгаалалтын бүсийн ангилалд хамаарч байна. Ойн санг бүрдүүлэн ургаж буй моддын зүйлийн бүрдлийн хувьд Шинэс 4806 га буюу талбайн 2.0 хувь, Хус 234 га буюу 0.1 хувь, Улиас 131 га буюу 0.05 хувь, Заг 223327 га буюу 96.4 хувь, Бургас 3182 га буюу талбайн 1.3 хувийг тус тус эзлэн ургаж байна.

Ховд аймагт 76 овогт хамаарах 405 төрлийн 1291 зүйлийн ургамал бүртгэсний дотор нэн ховор 59, ховор 130 зүйлийн ургамал бүртгэгдсэн байна.

Аймгийн нутаг дэвсгэрт нийтдээ 5 анги, 28 баг, 79 овогт хамаарах 429 зүйл сээр нуруутан амьтан бүртгэгджээ. 2017 онд аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар 14 сумдын 10177 км² талбайд аргаль хонь, 16 сумдын нийт 18033,9 км² талбайд янгир ямаа нь байршин тархсан байна.

Барилга, Хот байгуулалтын яамнаас 2011-2016 онд 27904 га газрыг Монгол улсын иргэнд өмчлүүлэх боломжтой гэж нөөцийг тогтоожээ. 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд 13643 иргэнд 2058.44 га газрыг өмчлүүлснээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2048.44 га газрыг 13640 иргэнд үнэгүй, аж ахуйн зориулалтаар 3 иргэнд 10 га газрыг төлбөртэй өмчлүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу төлбөрийн орлогыг 2021 онд 1,370.3, 2022 онд 2,671.2, 2023 онд 2,085.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөн баталж, Сангийн яамнаас 2021 онд Ковид -19 цар тахалтай холбоотой ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хязгаар ирүүлээгүй, харин ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 765.5 сая төгрөгөөр аймгийн ИТХ-аас төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталсан байна

БҮЛЭГ А. ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН Ч ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД АРГА ХЭМЖЭЭГ ТУСГААГҮЙ, ХҮРЭХ ТҮВШНИЙГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА

А.1.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай зарим хууль, тогтоомжийн заалтууд зөрчилдөж байна.

А.1.1.1 Байгалийн нөөцийн ашигласны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдаж 7 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, тус хуулийн 13.5¹-д зааснаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталж уг тогтоолыг 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн мөрдөж байна.

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-д “батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх” гэсэн заалт нь Засгийн газрын 2 дугаар тогтоолын 2.2. “Аймаг, нийслэлийн Засаг дарга саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай цагалбарын хувьд нийцэхгүй байна.

А.1.1.2 БНАТ-ийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 “Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана” гэсэн заалт нь татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.39 “хураагч” гэж татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалт хийх, хяналт шалгалт хийхээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа татварын албаны ажилтныг” хэлнэ гэсэн заалттай нийцэхгүйгээс сум, аймгийн түвшинд хэрэгжүүлэхэд дараах хүндрэлүүд бий болж байна. Үүнд.:

- Татвар хураах эрх бүхий албан тушаалтныг сумын Засаг дарга томилохгүйгээс тайланг хэн тушаах нь тодорхой бус, сумын ЗДТГ нягтлан бодогч тайлагнадаг,
- Аймаг сумдын Санхүү төрийн сангийн хэлтсийн тоо мэдээ татварын тоо мэдээ зөрүүтэй,
- Сумдын төсвийн орлогыг төлөвлөлт бодитой төлөвлөгдөхгүй, орлого тасрах эрсдэлтэй

А.1.1.3 БНАТ-ийн тухай хууль, ЗГ-ын 2 дугаар тогтоолд аймаг сумын ИТХ-д төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг хүргүүлэхээр заасан ч ИТХ-аас тухайн тайланг хэлэлцэж шийдвэр гаргах, хяналт хийх талаар заалт тусгаагүй байгаа нь хэрэгжилтийг хангах хөшүүрэг бий болохгүй байна. .

А.1.2 Аймгийн богино болон дунд хугацааны баримт бичгийг баталж, байгаль орчинтой холбоотой дэд хөтөлбөрүүд 81.8 хувьтай биелсэн байна.

А.1.2.1 “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020 онд батлагдсанаар Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, “Ногоон хөгжлийн бодлого” “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” зэрэг баримт бичгийг УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоог хангаж, давхардлыг арилгасан байна.

А.1.2.2 Алсын хараа 2050, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тулгуурлан аймгийн ИТХ-аас “Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Агаар, орчны бохирдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр”, “Ус аймгийн дэд хөтөлбөр”, “Ховд

¹ 13.5.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

аймгийн ногоон хөгжлийн хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”, “Стандарттай Ховд” хөтөлбөр гэсэн баримт бичгүүдэд байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг нөхөн сэргээхтэй холбоотой заалтуудтай уялдуулан баталсан байна.

А.1.2.3 Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс “Агаар, орчны бохирдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр”, “Ус аймгийн дэд хөтөлбөр”, “Стандарттай Ховд хөтөлбөр” “Ховд аймгийн ногоон хөгжлийн хөтөлбөр”-үүдийн 2021, 2022 оны хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн, “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Хүснэгт 1. Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Бодлогын баримт бичиг	2021 онд дэвшүүлсэн зорилт			2022 онд дэвшүүлсэн зорилт		
Аймгийн дэд хөтөлбөрүүд	нийт тоо	Хэрэгжүүлсэн тоо	хэрэгжилтийн хувь	нийт тоо	хэрэгжүүлсэн тоо	хэрэгжилтийн хувь
Агаар, орчны бохирдлыг бууруулах	29	26	82.9	30	26	77.6
Ус аймгийн дэд хөтөлбөр	16	12	80.8	23	20	80
Ногоон хөгжлийн хөтөлбөр	27	25	90.1	17	16	91.8
Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр				23	16	62.6
Стандарттай Ховд хөтөлбөр	7	5	82	9	7	86.6

Эх сурвалж: Аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрүүд

Дээрх хүснэгтээс харахад дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт 2021 онд 80.8-90.1, 2022 онд 62.6-91.8 хувьтай биелэгдэж 2022 онд төлөвлөсөн дараах арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна. Үүнд:

- Ховд аймгийн төвлөрсөн усан хангамжийн хайгуул хийж, нөөцийг тогтоох, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологийг судлах
- Холбогдох мэргэжлийн байгууллагуудыг усны чанар, найрлага тодорхойлох зөөврийн багаж, хэрэгслээр хангах,
- Буянт голын гольдролыг хамгаалах, сэргээх ажлыг хийж хэрэгжүүлэх
- Аюултай хог хаягдлын тооллогыг 2022-2023 онуудад хийж дүгнэлт гаргах
- Аймгийн хэмжээнд “Хоггүй Ховд” аян өрнүүлж, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, ажил үйлсээрээ манлайлсан 3 сум, 9 багуудыг хөтөлбөр хэрэгжих хугацаанд жил бүр байр эзлүүлж, шагнаж урамшуулах тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлж ажиллах

А1.3. Байгалийн нөөц ашиглагч байгууллагууд менежментийн төлөвлөгөөг батлуулан дүгнүүлж байгаа ч төрийн зарим байгууллагууд менежментийн төлөвлөгөөгүй байна.

А.1.3.1 Амьтны тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хуулиудад байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхтэй холбоотой менежментийн төлөвлөгөө боловсруулахаар заасан байхад орон нутагт байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим байгууллагууд менежментийн төлөвлөгөөгөө боловсруулаагүй, батлуулахаар хүргүүлсэн ч БОАЖЯ-наас баталж ирүүлээгүй байна.

Газрын тухай хуульд бодлогын баримт бичгийн хугацааг 12-16 жил байна гэж заасан ч аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний нь 2019 онд хугацаа нь дууссан, газар зохин байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй байна. Харин тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-аар батлуулан, биелэлтийг дүгнэн ажиллажээ.

Хүснэгт 2. Менежментийн төлөвлөгөөний судалгаа

Байгууллагын нэр	хэрэгжих хугацаа	биелэлт /хувиар/	тайлбар
БОАЖГазар /Ан агнуурын менежментийн төлөвлөгөө/	2018-2022 он	80	Аймгийн ерөнхий агнуурын 2022-2027 оны менежментийн төлөвлөгөөг “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ-тай хамтран боловсруулан БОАЖЯ-д хүргүүлсэн
Хар усан нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар	менежментийн төлөвлөгөөгүй		2022 онд менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-д хүргүүлсэн

нутгийн хамгаалалтын захиргаа				
Мянган угалзатын нурууны байгалийн цогцолбор газар	менежментийн төлөвлөгөөгүй		2022-2026 онд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-д хүргүүлсэн	
Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа	2019-2030 он	90.8	БОАЖЯ-ны 2019 оны А/565 тоот тушаалаар	
Хар нуур Ховд голын сав газрын захиргаа	2011-2021 он	74	БОАЖЯ-д менежментийн төлөвлөгөө боловсруулан хүргүүлсэн	
Ойн анги /орчны бүсийн менежментийн төлөвлөгөө/	2020-2024 он		Мянгад, Буянт, Эрдэнэбүрэн, Чандмань, Зэрэг сумдад батлуулсан	
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Ерөнхий төлөвлөгөөгүй		Тендер зарлагдсан	

Эх сурвалж: Харьяа байгууллагуудын менежментийн төлөвлөгөө

А.1.3.2 Байгалийн нөөцийг ашиглагч аж ахуй нэгж байгууллага нь Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэн менежментийн төлөвлөгөөг батлуулж мөрдөх үүрэгтэй байна. Аймгийн хэмжээнд Тефис майнинг ХХК, Талст молор ХХК, МоЭнКо ХХК, Вестерн холд ХХК, Дөргөн сумын Усан цахилгаан станц зэрэг хуулийн этгээдүүд БОАЖГ-аар жил бүр менежментийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг 90.1-97.2 хувийн хэрэгжилттэй дүгнүүлсэн байна.

А.1.3.3 Булган Үенч Бодонч голын сав газрын захиргаа, БОАЖГ ан агнуурын менежментийн төлөвлөгөөг жил бүр үнэлүүлж дүгнүүлж байгаа ч менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй төрийн байгууллагууд байна.Үүнд:

- Сум дундын ойн анги нь аймгийн ойн менежментийн төлөвлөгөө гаргаж батлуулаагүй
- Ой бүхий 5 суманд /Мянгад, Буянт, Эрдэнэбүрэн, Чандмань, Зэрэг/ менежментийн төлөвлөгөө байгаа болов ч төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулсан тайлан мэдээг аудитын явцад ирүүлээгүй
- Хар нуур Ховд голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө 2021 онд дууссан ч шинэчилж батлуулаагүй
- Хар усан нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газар нь менежментийн төлөвлөгөөгүй 2022-2026 оны онд батлуулахаар хүргүүлсэн ч батлагдаж ирээгүй байна.
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй

А.2.1 БОАЖ-ийн сайд нь Аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан ч биелэлтийг тооцох шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг зөв тодорхойлоогүйгээс үнэлгээ бодитой хийгдэхгүй байна.

А.2.1.1 Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулийн 13.5, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол, 2022 оны 2 дугаар тогтоолуудад тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих, арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгахыг зохицуулсан байна.

Хүснэгт 3.Байгаль орчин аялал жуулчлалын сайд төсвийн захирагч нартай байгуулсан гэрээний хэрэгжилт

Нэр	2021 он				2022 он			
	Дундаж үнэлгээ		Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн холбоотой заалт		Дундаж үнэлгээ		Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн холбоотой заалт	
	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилт ийн хувь	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилт ийн хувь	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилт ийн хувь	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилт ийн хувь
Аймгийн Засаг дарга	39	80.2	2	79	48	84.5	7	94.4
ХНХГСГЗ	31	88.4	3	92.9	32	91.3	3	96.3
ҮББГСГЗ	27	71.1	1	88.6	38	86.9	1	90

ХУНОУТХГ НХЗ	23	1	22	82.6	1	100
-----------------	----	---	----	------	---	-----

Эх сурвалж: Харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө

А.2.1.2 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай харьяа төсөв захирагч нарын байгуулсан

гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 1-7 арга хэмжээгээр тусгаж, биелэлтийг дүгнэж байгаа ч шалгуур үзүүлэлтийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу бодитой төлөвлөөгүй байна.

Хүснэгт 4. Байгаль орчин аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг харьцуулсан судалгаа

Арга хэмжээ	Хүрэх түвшин		Аудитаар
	2021	2022	
1.3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Аймгийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хуульд заасан хувь хэмжээнд хүргэсэн байна	2022 онд ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.752.7сая төг, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 198.5сая төг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 38.5 сая төг, газрын нөөцийн төлбөр 494.3 сая төгрөг төвлөрүүлэн хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулсан байна.	Хүрэх түвшинг зөрүүтэй тодорхойлсон, БТ тухай хуулийн дагуу зорилтот түвшнийг тодорхойлох тоон болон чанарын шаардлага хангаагүй
4.4 Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	10-аас доошгүй булгийн эхийг хашиж хамгаалан, тохижуулсан байна.		Тайлангаар 6 булгийн эх хашсан байхад биелэлтийг 100 хувиар дүгнэсэн
21. “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах		Ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан эсэх.	ХБТ тухай хуулийн дагуу зорилтот түвшний тодорхойлох тоон болон чанарын шаардлага хангаагүй
25.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллагад, айл өрхүүдэд орчин, үеийн шаардлага хангасан усны тоолуур нэвтрүүлэх		Жаргалант суманд ширхэг тоолуур	

Эх сурвалж: БОС-тай байгуулсан гэрээний биелэлтийн тайлан

А.2.2 Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаагүй байна.

А.2.2.1 Аймгийн Засаг даргын Байгаль орчин аялал жуулчлалын газартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зорилтот төвшинд үндэслэн үнэлэхэд 2021 онд 60.3, 2022 онд 14.7 хувьтай байгаа нь биелэлтийг бодитой дүгнээгүй, төсөв захирагчтай байгуулсан гэрээнд арга хэмжээг төлөвлөөгүй байна. Хүснэгт 5. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагч нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө

д/д	Байгууллагын нэр	2021 он					2022 он				
		Дундаж үнэлгээ		Үүнээс БНАТ-ын заалт		Аудитаар	Дундаж үнэлгээ		Үүнээс БНАТ-ын заалт		Аудитаар
		Тоо	%	Тоо	%	%	Тоо	%	Тоо	%	%
1	БОАЖГ	45	95	1	100	60.3	52	94.2	1	100	14.7
2	Ойн анги	25	87	-	-	-	-	-	-	-	-
3	Сумдууд	68	89.6	-	-	-	82	91.5	-	-	-

Эх сурвалж: Харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Мөн сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар заалт оруулаагүй, Сум дундын ойн ангитай 2022 оны гүйцэтгэлийн

төлөвлөгөө байгуулаагүй, дүгнээгүй, БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээг төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

Б1.1 Ан амьтан, ойн нөөцийг тогтоосон ч бусад байгалийн нөөцийг тогтоогүй байхад ашиглах төрөл дээд хэмжээг тогтоосон байна.

Б1.1.1 Ан амьтны тухай хуулийн 2022 онд аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтын хээрийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж ангийн нөөцийг тогтоосон байна.

Уг судалгаагаар аргаль хонины байршил 13 агнуурын бүс нутгийн хэмжээнд нийт 1305 аргаль хонь тэмдэглэгдэж, биологийн нөөц нь 2701 толгой, янгир ямааны байршил бүхий 17 агнуурын бүс нутгийн хэмжээнд 2079 тэмдэглэгдэж, биологийн нөөц нь 4620 толгой, тарваганы биологийн нөөц нь тархац нутгийн хэмжээнд 126220 толгой гэж үнэлэгдсэн байна.



Б1.1.2 Аймгийн ойн нийт нөөц 858027 шоо.метр байгаагаас 729873 шоо.метр нь байгалийн ойн нөөц, 124844 шоо.метр нь тармаг модны нөөц, 3310 шоо.метр нь бүлэг модны нөөц байна гэж Ойн судалгаа хөгжлийн төвөөс тодорхойлжээ.

Б1.2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу аймгийн хэмжээнд жил бүр байгалийн нөөцийг ашиглах саналыг хуулийн хугацаанд БОАЖЯ-д хүргүүлж, ахуйн болон ангийн зориулалтаар агнах ан амьтан, ургамлын нөөцийг ашиглах дээд хэмжээг дараах байдлаар тогтоожээ.

Хүснэгт 6. Байгалийн нөөцийг ашиглах төрөл дээд хэмжээ /сая.төг/

нөөцийн төрөл	зориулалт	хэмжих нэгж	2021 он	2022 он
Ан амьтан	агнуур	тоо, толгой	64	51
	ахуйн	тоо, толгой	4	30056
Ургамал	үйлдвэрлэл	кг		800

Аймгийн БОАЖГ-аас санал хүргүүлээгүй, ангийн нөөцийн судалгаагүйгээр 2022 онд БОАЖЯ-аас Алтай суманд ховор амьтан болох халиун буга агнах 2, саарал чоно, заарт хархны нөөц тогтоогоогүй байхад зөвшөөрөл олгож төлөвлөсөн нь Амьтны тухай хууль, Засгийн газрын 93 дугаар тогтоолд нийцэхгүй байна.

Б.1.2 Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Б1.2.1 Сумдын байгаль орчны мэргэжилтэн 2022 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг БНАТ-1 маягтын дагуу гарган аймгийн БОАЖГ-т ирүүлж, БНАТ-3 маягтын дагуу орлогын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга

хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт 2022 оны 7 дугаар сарын 29-ний 182 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Б1.2.2 Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн 2023 оны орлогын төлөвлөгөө, 2024-2026 оны байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг БНАТ-5 маягтын дагуу нэгтгэн аймгийн Засаг дарга болон БОАЖЯ-нд 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 73 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.


Б1.3 Зарим иргэн, хуулийн этгээд байгалийн нөөцийг зөвшөөрөлгүй ашиглаж байна.

Б1.3.1 БОАЖЯ-аас тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг аймаг бүрээр баталж, аймгийн ИТХ нь дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум бүрээр тогтоосноор БОАЖГ-аас ахуйн зориулалтаар агнах агнуурын амьтны тоонд үндэслэн эрхийн бичгийг сумдад олгож, сумын Засаг даргаас зөвшөөрөл олгожээ.

БОАЖС-ын 2021 онд сайдын А/701 тоот тушаалаар зэгсний зэрлэг гахай-4, тусгай зориулалтаар 2020 оны А/701, А/147, А/226 тоот тушаалаар 19 угалз, 45 тэх, 2022 онд А/208 тоот тушаалаар тусгай зориулалтаар угалз-18, тэх-31, буга-2 А/89 тоот тушаалаар ахуйн зориулалтаар саарал чоно-50, 2022 оны А/299 тоот тушаалаар сүргийн бүтэц болон тоо толгойг зохицуулах зорилгоор заарт харх-30000, тарвага-1500, зэрлэг гахай-6, агнуурын загас-2500 тус тус агнуулах зөвшөөрөл олгосон.

Ан агнуулах зөвшөөрөл олгогдсоноос 2021, 2022 онд тэх-7, угалз-4 агнаагүй, ахуйн зориулалтаар агнах зэгсний зэрлэг гахай, саарал чоноыг агнагдаагүй, загас, заарт хархыг бариагүй, тарвагыг агнаагүй шалтгаан нь тарваган тахалтай байсан.

Заарт хархыг агнаагүй гол шалтгаан нь ангийн чиглэлийн мэргэжлийн бусад байгууллагад тухайн онд агнах ангийн тоо хэмжээ, мэдээлэл ил тод нээлттэй бус, Заарт хархыг агнах төлбөр, хураамж 7200 төгрөг, түүхий эд буюу арьсны зах зээлийн үнэ ханш нь 2500 төгрөг байдаг зэргээс агнагдаагүй байна.



2021, 2022 онд тусгай хамгаалалттай газар нутгаас зөвшөөрөлгүйгээр монгол хадран загас 1, алтайн шар сугас загас 31, зэгсний зэрлэг гахай 2, заарт харх 116, хар сүүлт 1 агнагдсан, тусгай зөвшөөрөлгүйгээр аргаль 1, янгир ямаа 1 тус тус агнагдсаныг хууль хяналтын байгууллага шалгаж байна.


Тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг 2023 оноос дуудлага худалдааны журмаар зохицуулахаар хуульд өөрчлөлт орсон 2023 онд агнах ан амьтны зөвшөөрөл олгогдоогүй, мөн тоо толгойг сийрэгжүүлэх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор 60000 толгой онд агнах барих зөвшөөрлийг БОАЖЯ-аас олгосон агнах хугацаа болоогүй байна.

- 2021 онд Буянт суманд хуваарилсан Зэгсний гахай агнах 2 эрхийг бичгийг БОАЖГ-аас хүргүүлэхээр аймгийн Засаг даргад өгсөн боловч тухайн суманд хүлээлгэн өгөөгүй, тухайн 2 эрхийн бичгээр гахай агнасан эсэхийн нотлох боломжгүй,
- БОАЖГ-аас санал хүргүүлээгүй байхад 2022 онд ховор амьтан болох Халиун буга агнах зөвшөөрлийг Алтай суманд БОАЖЯ-аас олгосон,

Б1.3.2 Аймгийн хэмжээнд элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар 2 аж ахуйн нэгж байгууллага ашиглаж байгаагаас Байгалийн ургамлын тухай хуульд заасны дагуу элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг БОАЖГ-аас 2022 онд 1 аж ахуйн нэгж байгууллагад олгож, нөгөө нь зөвшөөрөл аваагүй үйл ажиллагаа явуулж байна.

Б1.3.3 Усны тухай хуулийн 28.4², 28.6³-д зааснаар хоногт 50 шоо метр хүртэлх ус ашиглагчийн ус ашиглах дүгнэлтийг аймгийн БОАЖГ гаргаж, ус ашиглах зөвшөөрлийг сумдын Засаг дарга олгох, хоногт 50-100 шоо метр ус ашиглах дүгнэлтийг Хар нуур Ховд голын сав газрын захиргаа, Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа, Үенч Бодонч, Булган голын сав газрын захиргаа тус тус гаргаж, ус ашиглах зөвшөөрлийг БОАЖГ олгох, хоногт 100 шоо метрээс дээш ус ашиглах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар гаргаж, ус ашиглах зөвшөөрлийг Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа, Үенч Бодонч, Булган голын сав газрын захиргаа тус бүртээ олгох хуулийн зохицуулалтай байна.

Аймгийн хэмжээнд 2021-2023 оны эхний 4 сарын байдлаар нийт 96 ус ашиглагч хуулийн этгээдийн ус ашиглах зөвшөөрлийг олгожээ.



Усны сав газрын захиргаанаас 2021-2023 онуудад гаргасан 57 ус ашиглах дүгнэлтээс 22 дүгнэлтэд үндэслэн БОАЖГ-аас зөвшөөрлийг олгосон нь байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангагдаагүй, өмнөх гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Мөн БОАЖГ-аас 2021-2023 онд 39 ус ашиглагчдад ус ашиглах дүгнэлт гаргасан ч сумдын Засаг даргаас зөвшөөрлийг олгоогүй байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа цайны газар, зочид буудал, зоогийн газар, зарим авто угаалгын газрууд, Үсчин, Халуун ус, Эсгийний үйлдвэрүүд, Махны үйлдвэрүүд, барилгын материал үйлдвэрүүд /боржуур, өнгөт хавтан, дээвэр, блок/ зэрэг олон ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд усны дүгнэлт гаргаж, усны зөвшөөрлийг бүрэн олгоогүй байна.

Б1.3.4 Аудитын хугацаанд газрын төлбөрийн ногдуулалтыг түүвэрлэн хянахад Газрын тухай хуулийн 7 болон 27 дугаар зүйлд заасны дагуу газар эзэмших гэрчилгээгүй, холбогдох шатны шийдвэргүйгээр газрын эзэмшиж байгаа, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтад заасан зам, шугам сүлжээний газрын суурь үнэлгээгээр ашиглагч байгууллагуудаас газрын төлбөрийг тооцоогүй, гэрчилгээ олгоогүйгээс газрын төлбөрийг бүрэн ногдуулаагүй байна. Тухайлбал:


² Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

³ Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоо метрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоо метр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоо метрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтад заасан зам, шугам сүлжээний газрын суурь үнэлгээгээр ашиглагч байгууллагуудаас газрын төлбөрийг тооцоогүй, гэрчилгээ олгоогүйгээс газрын төлбөрийг ногдуулалт хийгдээгүй,
- Жаргалант сумын нутаг дэвсгэрт айл өрх хувь иргэний эзэмшиж буй авто машины гажуудад газрын төлбөр ногдуулаагүй,
- Цэцэг суманд тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд газар эзэмших гэрээгүй, гэрчилгээгүй, ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөл аваагүй, /Саша ням транс ХХК 2019 он, Төр бум ХХК 2021 он, Эх газрын жинчид 2021 он, Мандал Хишиг ХХК 2021 он, Булган гол транс ХХК 2022 он, Алтайн даваа ХХК 2020 он/

Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж бүрэн ногдуулаагүйгээс төсөвт орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Б1.4.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу төлбөрийн орлогыг 2021 онд 1,370.3, 2022 онд 2,671.2, 2023 онд 2,085.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөн баталж, Сангийн яамнаас 2021 онд Ковид -19 цар тахалтай холбоотой ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хязгаар ирүүлээгүй, харин ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 765.5 сая төгрөгөөр аймгийн ИТХ-аас төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталсан байна.



Сангийн яамнаас хянасан жилийн төсвийн хязгаараас газрын төлбөрийн орлогыг 2021 онд 96.7, 2023 онд 77.0 сая төгрөгөөр тус тус багаар баталсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8⁴, 14.2⁵, 14.2.1⁶ гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Хүснэгт 7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Орлогын төрөл	2021 он				2022 он			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	36.5	47.9	(11.4)	131.2	38.5	31.6	6.9	82.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	215.0	224.2	(9.2)	104.3	198.5	177.4	21.1	89.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	765.5	1,110.5	(345.0)	145.1	1,939.9	1,379.0	560.9	71.1
Газрын нөөцийн төлбөр	353.3	188.8	164.5	53.4	494.3	915.7	(421.4)	185.3
ДҮН	1,370.3	1,571.4	(201.1)	114.7	2,671.2	2,503.7	167.5	93.7

Эх сурвалж: Аймгийн ИТХ-аар баталсан төсвийн төлөвлөгөө, ТЕЗ-ын 2021, 2022 оны санхүүгийн тайлан

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 14.7 хувь буюу 201.1 сая төгрөгөөр илүү бүрдүүлсэн, 2022 онд 167.5 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар орлогыг дутуу бүрдүүлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэр төрлөөр авч үзвэл: 2021 онд байгалийн ургамлын нөөц ашигласны орлогыг төлөвлөснөөс 11.4, ан амьтны нөөцийн орлого 345.0, ус, рашааны нөөц ашигласны орлогыг 9.2 сая төгрөгөөр илүү бүрдүүлж, газрын төлбөрийн орлогыг 164.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Харин 2022 онд газрын төлбөрийн орлогыг 421.4 сая төгрөгөөр орлогыг илүү бүрдүүлсэн нь өмнөх оны газрын төлбөрийн ногдуулалтыг тайлант онд оруулсантай


⁴ “Жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

⁶ 14.2.1 жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

холбоотой, бусад нөөцийн орлогыг 6.9-560.9 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь 2022 онд ан амьтан агнах тоо хэмжээ буурсан байна.

Аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын 55.1-70.7 хувийг ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлжээ. Засгийн газрын 2018 оны А/182 дугаар тогтоолд заасны дагуу аймгийн ИТХ-ын 2021 оны 5/08 тоот тогтоолоор “аймгийн газрын



үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн итгэлцүүр”-ийг шинэчлэн тогтоосон байна.

Б1.4.2 Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁷, Засгийн газрын А/187 дугаар тогтоолын 3.5.2-д “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан заавраар батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан талбайн гудамж уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа /карьер, овоолго, хиймэл нуур, аж ахуй дотоодын зам, шугам сүлжээний гэх мэт газар хэсгийн газрын төлбөрийг тухайн нутаг дэвсгэрийн хот, тосгон, бусад суурины үнэлгээний бүсчлэлийн хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газрын хамаарагдах бүсчлэлийн нийт га газрын жилийн төлбөрийн дээд хэмжээг хоёр дахин өсгөж тооцно” гэсэн заалтын дагуу зарим аж ахуйн нэгж байгууллагын газрын төлбөрийг бүрэн ногдуулаагүй байна. Үүнд:

- Төфис майнинг ХХК-ийн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанийн 2021, 2022 онд газрын төлбөрийн орлогыг 117.8 сая төгрөгөөр дутуу ногдуулсан,
- Булган сум газрын төлбөрийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн,
- Буянт сумын Тусгай хамгаалалтын газар нутагт үйл ажиллагаа явуулдаг Элсэн шанаа, Борцгор хотон, Цагаан бөлбөө жуулчны баазууд газар,
- Эрдэнэбүрэн сумын тусгай хамгаалалтын газар нутагт үйл ажиллагаа явуулдаг Мөнх цастын хишиг ХХК газрын гэрчилгээгүй, газрын төлбөр ногдуулаагүй,

Б1.4.3 Аймгийн хэмжээнд усыг үйлдвэр үйлчилгээндээ ашиглаж буй ус ашиглагч нарт Усны тухай хуулийн дагуу усны дүгнэлтийг гаргаж, зөвшөөрөл олгосноор төсөвт 335.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх, ус ашиглах гэрээг байгуулахдаа мэргэжлийн байгууллагуудын ус ашиглах дүгнэлтийг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээг дүгнэхдээ ус ашиглалтын тайланд дүн шинжилгээ хийж, үр дагаврыг бүрэн үнэлээгүйгээс 423.9 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

⁷ Эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурины газрын суурь үнэлгээнд тогтоосон газрын төлбөрийг инженерийн хангамж, ашиглалтын зориулалт, байршил, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон ногоон бүсийг хамгаалах шаардлагыг харгалзан тооцсон итгэлцүүрээр энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан хязгаарт багтаан өсгөж, бууруулж болно. Итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

- Цэцэг суманд нүүрс тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 35 компаний 1210 тээврийн хэрэгсэл нүүрс тээвэрлэхдээ усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа тул ус ашиглах дүгнэлтийг гаргаж, зөвшөөрлийг олгож 95.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжтой,
- Аймгийн хэмжээнд цайны газар, зочид буудал, зоогийн газар, зарим авто угаалгын газрууд, Үсчин, Халуун ус, Эсгийний үйлдвэрүүд, Махны үйлдвэрүүд, барилгын материал үйлдвэрүүд /боржуур, өнгөт хавтан, дээвэр, блок/ зэрэг олон ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд усны дүгнэлт гаргаагүй, БНАТ-ийн орлогын ногдуулалтыг бүрэн хийгээгүй 239.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжтой,
- Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргаа нь МОЭНКО ХХК- тай ус ашиглах гэрээг байгуулахдаа Усны газраас гаргасан дүгнэлтийг үндэслээгүйгээс усны төлбөрийг 394.5 сая төгрөгөөр, ,
- МОЭНКО ХХК нь зам талбайн тоосжилтод ашигласан усны хэмжээ гүйцэтгэлээр бага байгаа нь уг ажлыг ус ашиглах дүгнэлтэд заасан норм, хэмжээгээр хийгээгүйгээс 22.0 сая төгрөгөөр,
- МОЭНКО ХХК нь ус ашиглах дүгнэлт, гэрээнд заасан зөвшөөрсөн хэмжээнээс илүү ус ашигласан усны төлбөрийг шатлан өсгөх хувиар нэмэгдүүлэн тооцоогүй 7.4 сая төгрөгөөр орлогыг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн

Б.2.1. Байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцон батлаагүй байна.

Б.2.1.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁸-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 2021 онд арга хэмжээгээр төлөвлөөгүй 225.3, 2022 онд 23 арга хэмжээнд 348.0, 2023 онд 66 арга хэмжээнд 670.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөн баталсан байна

Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардал /сая.төг/

он	2021 он			2022 он			2023 он		
Орлогын төлбөр	төлөв лөгөө	Хуулиар зарцуулах доод хэмжээ	Аймгийн ИТХ-аар баталсан	төлөв лөгөө	Хуулиар зарцуулах доод хэмжээ	Аймгийн ИТХ-аар баталсан	төлөв лөгөө	Хуулиар зарцуулах доод хэмжээ	Аймгийн ИТХ-аар баталсан
Байгалийн ургамлын нөөц ашигласны	36.5	5.5		38.5	5.8	4.4	43.5	6.5	5.8
Ан амьтны нөөц ашигласны	765.5	382.8		1,940.0	970.0	210.1	1,094.9	547.4	400.0
Ус, рашааны нөөц ашигласны	215.0	75.3		198.5	69.5	63.0	205.0	71.8	137.7
Газрын төлбөр	353.3	53.0		494.3	74.1	70.5	742.3	114.3	127.0
ДҮН	1,370.3	516.5	225.3	2,671.3	1,119.4	348.0	2,085.7	740.0	670.5

Эх сурвалж: Аймгийн ИТХ-аар баталсан төсвийн төлөвлөгөө, ТЕЗ-ын 2021,2022 оны санхүүгийн тайлан


Дээрх хүснэгтээс үзэхэд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг 2021 онд 291.2 сая төгрөг буюу 43.6 хувь, 2022 онд 771.4 сая төгрөг буюу 31.1 хувь, 2023 онд 69.5 сая төгрөг буюу 90.6 хувиар тус тус төлөвлөн баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

⁸ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

⁹ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: “Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 15 хувь, Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого -50 хувь, Газрын нөөцийн төлбөрийн орлого -15 хувь, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 35 хувь”

Мөн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг 2021 онд 225.3 сая төгрөгөөр батлахдаа хуульд заасан хувь хэмжээний доод хязгаараас тооцоогүй нийт дүнгээр баталсан.

2022 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцоход 970.0 сая төгрөг байхад 759.9 сая төгрөгөөр дутуу, 2023 онд ус, рашааны ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээнээс 65.9 сая төгрөгөөр илүү нэмэгдүүлэн баталсан нь холбогдох хууль тогтоомжийн заалтыг мөрдөөгүй байна. Сумдын ИТХ-аар баталсан төсвийг хянахад дараах зөрчил илэрлээ.




- Булган, Буянт, Манхан, Мянгад, Үенч, Ховд, Цэцэг, Жаргалант сумууд 2023 оны байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг хэрэгжүүлэх арга хэмжээ бүрээр батлаагүй,
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг байгалийн нөөцийн нэр төрлөөр батлаагүй,
- 2022 оны газрын төлбөрийн давсан 421.4 сая төгрөгийн орлогыг 2023 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд төлөвлөөгүй,

Б.2.2. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан арга хэмжээнд зарцуулахгүй, хүрэлцэхгүй байгаа бусад арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Б.2.2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардалд Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 3.5¹⁰, 3.6¹¹-д аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг санхүүжүүлэхээр зохицуулсан байна.

2021 онд 37 арга хэмжээг хэрэгжүүлснээс 15 арга хэмжээ, 2022 онд 57 арга хэмжээ хэрэгжүүлснээс 43 арга хэмжээг аймаг сумууд байгаль хамгаалах сангийн зардлыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, ан амьтны менежментийн төлөвлөгөө, засаг даргын жил бүрийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2021 онд 196.7, 2022 онд 427.0 сая төгрөгийг зарцуулснаас 2021 онд нийт



¹⁰ Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ:

¹¹ Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр, энэ журмын 3.5.6, 3.5.7, 3.5.8-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ:

зарцуулалтын 41.2 хувь, 2022 онд 53 хувийг хуульд заасны дагуу зарцуулаагүй буюу урсгал үйл ажиллагааны зардал, хөрөнгө бэлтгэх, шатахууны зардалд зарцуулагдсан байна.

Нийт зардлын 9 хувийг шатахуун, 42-69.4 хувийг урсгал үйл ажиллагааны зардалд, 14.4-38.9 хувийг хөрөнгө бэлтгэх, 7-9 хувийг бараа материал, бусад зардалд тус тус зарцуулжээ.

Аудитаар аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хянахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны БОХНСАХЗ-аас авто машин худалдан авах гэрээ байгуулан 7 сард хүлээлгэн өгөх нөхцөлтэй 32.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон одоог хүртэл нийлүүлэгдээгүй,
- Аймгийн БХС-гаас 2021 онд 36.2, 2022 онд 41.1 сая төгрөгийг төслийн ажилчдын цалинд зарцуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн тодорхой бус,
- Дуут сум өмчийн түрээс, газрын төлбөрийн зардалд,
- Цэцэг сум 8.5 сая төгрөгийг тохижилтын үйл ажиллагаанд,
- Үенч сум 4.5 сая, Зэрэг сум 5.6 сая төгрөгөөр сумын тэжээлийн нөөц бэлтгэсэн,
- Манхан, Булган, Дарви, Эрдэнэбүрэн, Ховд зэрэг сумууд ЗДТГ-ын бараа материалын үнэ төлсөн,
- Багийн Засаг дарга нарт Мөнххайрхан 4.0, Цэцэг сум 5.0 сая төгрөгөөр мотоцикл худалдан авсан,
- Алтай сум 5, Булган 3.4, Буянт 5.1, Мөст 1.5, Мянгад 1.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны шатахууны зардалд тус тус зарцуулсан,
- Ховд сум 2021, 2022 онд 11.5 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан нь хууль журмын дагуу зарцуулаагүй,

Харин Дарви, Мөст, Цэцэг сумууд 4.5 сая төгрөгийг идэвхтэн байгаль хамгаалагч нарыг дэмжих үйл ажиллагаанд, Мөст сум 3.5, Үенч сум 2.9 сая төгрөгийн сургалт сурталчилгааны зардалд зарцуулсан нь байгаль хамгаалахад иргэдийн оролцоог дэмжсэн үр дүнтэй ажлууд хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл /сая.төг/

Нөөцийн төрөл	2021 он		2022 он	
	Хуульд заасны дагуу тухайн жилд зарцуулах доод хэмжээ	байгалийн нөөцөд зарцуулсан дүн	Хуульд заасны дагуу тухайн жилд зарцуулах доод хэмжээ	байгалийн нөөцөд зарцуулсан дүн
Байгалийн ургамал	5.5		5.8	
Ан амьтан	382.8	16.6	970.0	6.2
Ус, рашаан	75.3	23.5	69.5	38.0
Газар	53.0	8.9	74.1	15.9
тэрбум мод хөтөлбөрт		16.2		44.7
хог хаягдал цэвэрлэх		60.4		95.6
ДҮН	516.5	115.6	1,119.4	200.4

Эх сурвалж: сумдын ЗДТГ-ын 2021, 2022 оны санхүүгийн баримт, санхүүгийн тайлан

Батлагдсан төсвийг хууль, журамд заасны дагуу зарцуулаагүй гол шалтгаан нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний шаардлагатай зардлыг төлөвлөхдөө газар зохион байгуулалтын төлөвлөгөө, ойн, ан агнуурын болон усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг төлөвлөөгүй, байгаль орчны салбарын байгууллага хоорондын уялдаа сул, салбарын хууль тогтоомж, шийдвэрийн талаарх мэдээллийг тухай бүр өгдөггүй, мэргэжлийн албан хаагчийн санал хүсэлтийг хүлээн авдаггүй зэргээс хамаарч байна.

БҮЛЭГ В.ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ ТОДОРХОЙ БУС БАЙНА.

В.1.1 Байгаль орчны цахим сангийн мэдээлэлтээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн ч мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

В.1.1.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтад зааснаар 2022 оны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аймгийн 16 сумуудын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн eic.mn/finance/ цахим мэдээллийн санд мэдээллийг байршуулж улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн ч зарим сумдын мэдээлэл дутуу байна. Тухайлбал, Алтай, Дөргөн, Дуут сумдын байгаль хамгаалагч арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээг оруулаагүй, Булган, Буянт, Зэрэг, Мянгад, Үенч, Ховд, Цэцэг, Жаргалант сумууд орлого, зарцуулалтын мэдээллээ зөрүүтэй байршуулсан байна.

Засгийн газрын 2 дугаар тогтоол хэрэгжиж байгаль орчныг хамгаалах байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний орлогын төлөвлөгөө, зардлын гүйцэтгэлийн 2022 оны мэдээг тулгахад цахим сайтад орлогыг 115.7, зардлын гүйцэтгэлийг 76.0 сая төгрөгөөр илүү, хуульд заасан хэмжээгээр тооцон зарцуулах зардлыг 135.8 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Хүснэгт 10. Системийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн судалгаа /сая.төг/

Үзүүлэлт	БНАТ-ийн нийт орлого	БОХ, БННСАХ-ний зарцуулах нийт зардал	Нийт зардлын гүйцэтгэл
eic.mn/finance/	2,618.9	983.5	503.2
аудит	2,503.2	1,119.3	427.2
зөрүү	115.7	(135.8)	76.0

Эх сурвалж: eic.mn/finance/

В.1.1.2 Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д “Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ” гэж заасан ч хэрэгжилт хангагдахгүй байна.

В.1.1.3 Аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 152 тоот албан бичгээр ирүүлсэн татвар төлөгчдийн 2022 оны татварын тооцооллын үлдэгдлийн судалгаанд тусгасан мэдээлэлд сумдын ЗДТГ-т татварын ногдуулалт хийж тайлагнасан нь тухайн байгууллагын санхүүгийн тайлан дахь тоо мэдээллээс зөрүүтэй байгаа нь сумын ЗДТГ-ын холбоотой бус үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, иргэнд ногдуулан тайлагнаагүй байна.

В.1.1.4 Засгийн газрын 2 дугаар тогтоолд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний орлого, зарцуулалтын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн эсэх, хяналт тавихад олон нийтийн оролцоог хангасан талаарх баримт мэдээлэлгүй, мэдээллийн ил тод нээлттэй байдал бүрэн хангагдаагүй байна.

В.1.1.5 Аймгийн БОАЖГ-ын салбарын асуудлыг хариуцсан мэргэжилтнүүд сумдын байцаагчдын оруулсан мэдээллийг БНАТ-ын цахимд системд хянадаггүй зөвхөн ахлах мэргэжилтэн хяналт хэрэгжүүлж байна.

В.1.2 Төрийн байгууллагуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын талаарх мэдээлэл зөрүүтэй байна.

В.1.2.1 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹², Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1¹³-д зааснаар аймгийн төрийн захиргааны байгууллагууд нь БНАТ-ийн орлогын

¹² Агентлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана.

¹³ хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа яам, агентлагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх төлөвлөлт, ногдуулалт, төлөлтийн талаарх тоо мэдээлэл дараах байдлаар илэрхийлсэн байна.

Хүснэгт 11. БНАТ-ын орлогын ногдуулалт, төлөлт

/сая.төг/

он	байгууллага	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		Ан амьтны нөөц ашигласны төлбөр		Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	
		ногдуулалт	төлөлт	ногдуулалт	төлөлт	ногдуулалт	төлөлт
2021	Татварын хэлтэс	15.8	47.9	227.9	1,273.7	133.4	220.8
	СТСХэлтэс	36.5	47.9	765.5	1,110.6	215.0	224.2
	зөрүү	(20.7)	-	(537.6)	163.1	(81.6)	(3.4)
2022	Татварын хэлтэс	41.4	31.6	1,323.1	1,500.1	239.8	206.2
	СТСХэлтэс	38.5	31.6	1,939.9	1,378.8	198.5	177.4
	зөрүү	2.9	-	(616.8)	121.3	41.3	28.8

Эх сурвалж: Татварын мэдээ, аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад аймгийн Татварын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтсийн БНАТ-ын орлогын төлөвлөлт, ногдуулалтын талаарх мэдээлэл зөрүүтэй, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын дансанд улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн дүнгээр зөрүү үүссэн байна.

В1.2.2 Газрын төлбөрийн орлогын төлөвлөлт, ногдуулалт, төлөлтийн талаарх аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын тоо мэдээлэл хооронд зөрүүтэй байна. Хүснэгт 12. Газрын төлбөрийн орлого, төлөлт /сая.төг/

байгууллага	2021 он		2022 он		2023 он
	ногдуулалт	төлөлт	ногдуулалт	төлөлт	төлөвлөгөө
Татварын хэлтэс	460.5	172.1	1,043.9	559.7	
СТСХэлтэс	353.3	188.9	494.3	915.7	742.3
ГХБХБГазар	200.4	189.6	706.1	823.0	825.0

Эх сурвалж: ГХБХБГ-аас ирүүлсэн мэдээлэл, татварын судалгаа, аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Иймд байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн орлогын талаарх тоо мэдээлэл зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоогүйгээс шалтгаалсан байна.

В.2.1. Байгаль орчны чиглэлийн байгууллагууд хуульд заасны дагуу хяналт хэрэгжүүлсэн ч ахиц гараагүй, ГХБХБГ -ын хяналт сул байна.

В.2.1.1 Аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагууд 2021 онд 26, 2022 онд 32 удаа хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 13. Мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт

Байгууллагын нэр

2021 он

2022 он

БОАЖГ

17

6

Хар нуур Ховд голын сав газар

9

26

Эх сурвалж: БОАЖГ, ХНХГСГЗ-ын тайлан

Уг хяналт шалгалтуудаар ус ашиглах гэрээнд заасан зөвшөөрсөн уснаас 289 778 804м/3 усыг хэтрүүлэн ашигласан, ус ашиглаж буй авто угаалгын газрууд нь ус ашиглах дүгнэлтийг гаргуулаагүй, байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулаагүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, 5 иргэн зөвшөөрөлгүй гар аргаар худаг цооног гаргасан зэрэг зөрчлүүдийг илрүүлэн холбогдох хууль тогтоомж, журмыг танилцуулан мэдээлэл өгч, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна.



В 2.1.2 Байгаль орчинтой холбоотой 2021 онд байгаль орчны, эсрэг гэмт хэрэг, зөрчил 23 бүртгэгдсэнээс хууль бусаар ан амьтан агнасан, худалдсан 6, байгалийн ургамал түүж бэлтгэсэн 2, хууль бусаар ашигт малтмал олборлосон 15 гэмт хэрэг, 2022 онд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд 18 тохиолдол бүртгэгдэн шалгагдаж байна.

В 2.1.3 Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2022 онд төлөвлөгөөт бус хяналтыг Булган суманд хийж газар зохион байгуулалт, хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгүүлээгүй, үйлчилгээний зориулалтаар олгох газрыг дуудлага худалдаагаар олгоогүй, газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд хамруулаагүй, Булган, Алтай, Зэрэг, Дарви, Дөргөн, Мянгад, Жаргалант, Манхан сум, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хийгдсэн шалгалтаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй, Алтай, Дарви, Булган сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө үндэслэл муутай хийгдсэн, төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, газрын нэгдмэл сангийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамруулаагүй зэрэг зөрчлүүдэд 6 заалт бүхий цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

В 2.1.4 Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт аудитад шаардлагатай баримт мэдээллийг ирүүлэх талаар 2 удаа албан тоот хүргүүлэн 2021, 2022 онд газартай холбоотой хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан, холбогдох мэдээллийг ирүүлээгүйгээс үзэхэд хяналтын чиг үүрэг хэрэгжүүлээгүй байна.



В 2.1.5 Аудитаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг тооцоход 2021 онд аймгийн дундаж 15.4 хувьтай, Булган сум 2.5, Буянт сум 1.2, Зэрэг сум 10.0 хувь доогуур, 2022 онд аймгийн дундаж 38.1 хувьтай, Алтай сум 5.4, Манхан сум 12.7, Зэрэг сум 22.4, Манхан сум 12.7, Мөст сум 21.9, Мөнххайрхан сум 30.2, Үенч сум 12.9, Цэцэг сум 18.8, Эрдэнэбүрэн сум 15.7 хувьтай буюу аймгийн дунджаас доогуур хувьтай байна.

В2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн ч зөрчил буураагүй байна.

В 2.2.1 Аймаг сумдын өөрөө удирдах байгууллагаас БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг 2021 онд 112, 2022 онд 123, 2023 онд 46 удаа хийж хэрэгжүүлсэн байна.

Сумдын ИТХ-аар хийгдсэн хяналт шалгалтаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг торлох, хууль бус ан агнах, бэлчээрийг зүй зохисгүй ашиглах, намар өвлийн улиралд малчид түлээ түлш бургас модны хаягдал ашиглах заг түүх, сумдын хилийн зааг бүс нутаг болон зуслан өвөлжөөний бүс нутагт зөвшөөрөлгүй зэргэлдээх сумын малчид ирж нутагладаг зэрэг зөрчлүүд, Татварын хууль тогтоомжийн хэрэгжилт, сум орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажиллаж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн үүрэг чиглэл өгчээ.

Зөрчилтэй асуудлыг БИНХ болон сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээ ажилласны үр дүнд сум орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө биелсэн, иргэдийн хууль бус ан агнах байдал буурсан, зөвшөөрөлгүй татсан торыг буулгасан, бэлчээр сэлгэн нүүх, эмийн болон хүнсний зориулалтын ургамлыг зүй зохистой түүж ашиглах зэрэг олон эерэг хандлага бий болжээ.

Аймгийн ИТХ-аас Мөст, Мөнххайрхан, Үенч, Цэцэг, Эрдэнэбүрэн сумдад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг 24.2 хувьтай хангасан гэж дүгнэн, сумдын БНАТ-ын орлогын 8-9 хувийг ан амьтны төлбөрийн

орлого бүрдүүлдэг ч тухайн ан амьтныг хамгаалах арга хэмжээнд зарцуулдаггүй, төлбөрийн орлогыг бодитой ногдуулж төлөвлөдөггүй, хуульд заасан хэмжээгээр тооцон батлаагүй нь сумдын ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга нарын хуулийн мэдлэг дутмаг, сумын байгаль хамгаалагч ажилдаа хандах хандлага, мэргэжлийн ур чадвар сул зэрэг алдаа зөрчлүүдийг илрүүлсэн байна.

Аудитаар нийт 1,197.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 34.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 31.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 394.5 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, 737.2 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ТУСГААГҮЙ, ХҮРЭХ ТҮВШНИЙГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛООГҮЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ЗАРЦУУЛААГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ ТАНАА

- Төрийн байгууллагуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын талаарх тоон мэдээлэлд нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэн орлогыг хуулийн дагуу бодитой төлөвлөж батлах
- Аймгийн ИТХ-аар баталж байгаа дэд хөтөлбөрүүдийн суурь түвшин, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгон баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.БОЛОРМАА ТАНАА

- Харьяа төсвийн захирагчидтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн талаар хүрэх үр дүнгийн зорилт, шалгуур үзүүлэлтийг оновчтой тусгах, сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээг тусган ажиллах
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан арга хэмжээнд төлөвлөн, зардлыг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж ажиллах
- Усны тухай хуулийн 12.1.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж усны төлбөрийн орлогыг хууль, тогтоомжид заасны дагуу төлөвлөж зарцуулах

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан арга хэмжээнд төлөвлөн, зардлыг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж ажиллах

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА Л.БАТБАЯР, ХАР НУУР ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.НЯМДАВАА НАРТ

- Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах.
- Байгалийн нөөц зөвшөөрөлгүй ашиглаж байгаа иргэн, ААН-үүдэд хяналт хэрэгжүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
- Усны тухай хуулийн дагуу усны дүгнэлтийг гаргаж, зөвшөөрөл олгосноор төсөвт оруулах орлогыг бүрэн бүрдүүлж ажиллах

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, цахим мэдээллийн сангийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар иргэд, олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж ажиллах

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ТӨГӨЛДӨР ТАНАА

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулан батлуулах
- Газар эзэмших гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн компанийн газрыг хууль хяналтын байгууллагатай хамтран чөлөөлүүлэх,
- Засгийн газрын 182 тоот тогтоолын 7 дугаар хавсралтад заасны дагуу халаалт, эрчим, зам, шугам сүлжээ ашиглагч байгууллагуудад газрын төлбөрийн ногдуулалт хийж ажиллах
- Газрын төлбөрийн орлогын ногдуулалт төлөлтөд хяналт хэрэгжүүлэн сум, аж ахуйн нэгж, иргэн бүрээр төлөгдөөгүй үлдэгдлийг гаргаж, нөхөн ногдуулалт хийж дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.БАТЦЭЦЭГ ТАНАА

- Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн Байгалийн нөөцийн орлого ногдуулалтыг хуульд нийцүүлэн тухай бүр хийж, орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэн ажиллах
- Байгалийн нөөцийн орлогын гүйцэтгэлийн мэдээ зөрүүтэй байдалд хяналт хэрэгжүүлэн, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР